



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/38

Номгон

Барьцаа хөрөнгө суллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 444 дүгээр тогтоол "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2.9.1, 2.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 49 дүгээр албан бичиг, Баянговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 26 дугаар албан бичиг, Барилга байгууламжийн ашиглалтад оруулах комиссын 2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 2023/14 дүгээр дүгнэлтийн дагуу Баянговь сумын сургуулийн дотуур байрны их засварын ажлын чанарын баталгаа болох 28,373,090 (Хорин найман сая гурван зуун далан гурван мянга ерэн) төгрөгийг чөлөөлөхийг Санхүү төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т үүрэг болгосугай.

2.Баянговь сумын сургуулийн дотуур байрны барилгын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл)-т, Баянговь сумын Ерөнхий боловсролын сургууль (Ш.Уранчимэг)-д тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

625010105